



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот


┌ Нийслэлийн өмчид барилга байгууламж ┐  
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж ашиглалтад орсон, нийт 1,246,742,019 (нэг тэрбум хоёр зуун дөчин зургаан сая долоон зуун дөчин хоёр мянга арван ес) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100131

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн  
45 дугаар тогтоолын хавсралт т



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглал -тад орсон он	Бүртгэх үнэ (төгрөгөөр)	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Халуун ус, ахуйн үйлчилгээний барилга байгууламж:	Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо	2021	517,782,857.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ
2	Яармаг худалдааны төвийн барилга байгууламж	Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо	2021	370,895,939.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ
3	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 43 дугаар хороо	2021	49,634,712.0	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
4	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо	2021	45,559,466.0	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
5	Агуулахын барилга	Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороо	2017	262,869,045.0	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Хүнс Хангамж төв ОНӨААТҮГ
	Нийт дүн			<b>1,246,742,019.0</b>		